

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2020 ~~2022~~ оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

ИРГЭНИЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

~~1 дүгээр зүйл. Иргэний хуулийн 451 дүгээр зүйлд доор дурдсан агуулгатай 451.4, 451.5 дахь хэсэг нэмсүгэй:~~

~~“451.4. Мөнгөн зээлийн үйл ажиллагаа эрхлэх этгээдээс олгох мөнгөн зээлийн үйл ажиллагааг хуулиар зохицуулна.~~

~~451.5. Барьцаалан зээлдүүлэх журмаар олгох мөнгөн зээлийн үйл ажиллагаанд зөвхөн хөдлөх хөрөнгө барьцаалж болно.”~~

1 дүгээр зүйл. Иргэний хуулийн 452 дугаар зүйлийн 452.2 дахь хэсгийн “эрх бүхий” гэсний дараа “этгээд, мөнгөн зээлийн үйл ажиллагаа эрхлэх” гэж нэмсүгэй.

2 дугаар зүйл. Иргэний хуулийн дараах хэсгийг зүйл, хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

1/282 дугаар зүйлийн 282.1, ~~282.2~~ дахь дэх хэсэг:

“282.1. Нэг удаагийн шинжтэй, эсхүл ашиг олох зорилгогүй зээлийн гэрээгээр талууд хэлэлцэн тохиролцож хүү тогтоож болно.”

~~282.2. Хүүгийн хэмжээ нь энэ хуулийн 451.4-т заасан мөнгөн зээлийн үйл ажиллагаа эрхлэх этгээдээс олгох зээлийн хүүгийн дээд хэмжээнээс хэтрэхгүй байна.”~~

2/286 дугаар зүйл:

“286 дугаар зүйл. Барьцаалан зээлдүүлэх журмаар болон байнга ашиг олох зорилгоор зээл олгох

451.4 **286.1. Мөнгөн зээлийн үйл ажиллагаа эрхлэх этгээдээс олгох мөнгөн зээлийн үйл ажиллагааг хуулиар зохицуулна.**

451.5 **286.2. Барьцаалан зээлдүүлэх журмаар олгох мөнгөн зээлийн үйл ажиллагаанд зөвхөн хөдлөх хөрөнгө барьцаалж болно.**”

~~2/452 дугаар зүйлийн 452.2 дахь хэсэг:~~

~~“452.2. Зээлдэгч гэрээнд заасан хугацаанд авсан зээлээ өргүүлэн төлөөгүй бол гэрээнд заасны дагуу зээлдүүлэгчийн үндсэн хүүгийн хорин хувиас хэтрэхгүй хэмжээний нэмэгдүүлсэн хүү төлөхөөр гэрээнд зааж болно. Банк, зээлийн үйл~~

~~ажиллагаа эрхлэх эрх бүхий этгээд, мөнгөн зээлийн үйл ажиллагаа эрхлэх этгээдээс өлгөх зээлд анзыг хөрөглөжгүй.”~~

3 дугаар зүйл. Иргэний хуулийн 283 дугаар зүйлийн 283.3, 283.4 дэх хэсэг хэсгийг, ~~286 дугаар зүйлийг~~ тус тус хүчингүй болсонд тооцсугай.

4 дүгээр зүйл. Энэ хуулийг Мөнгөн зээлийн үйл ажиллагааг зохицуулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

~~2020~~ 2022 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

ИРГЭНИЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙГ ДАГАЖ МӨРДӨХ ЖУРМЫН ТУХАЙ

1 дүгээр зүйл. ~~2020 оны ... дугаар сарын ... ны өдөр баталсан Иргэний хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль талууд өөрөөр тохиролцоогүй бол Талууд өөрөөр тохиролцоогүй бол 2022 оны ... дугаар сарын ...-ны өдөр баталсан Иргэний хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулиар зохицуулсан харилцаа нь уг хууль хүчин төгөлдөр болохоос өмнө байгуулагдсан барьцаалан зээлдүүлэх газар, иргэнээс олгох зээлд хамаарахгүй.~~

2 дугаар зүйл. Энэ хуулийг Мөнгөн зээлийн үйл ажиллагааг зохицуулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2020 2022 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

ИРГЭНИЙ ХЭРЭГ ШҮҮХЭД ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд 132²
132³ дугаар зүйл нэмсүгэй:

**“132³ дугаар зүйл. Мөнгөн зээлийн үйл ажиллагаа эрхлэх
этгээдээс олгох зээлийн гэрээтэй холбогдолтой
хэрэг хянан шийдвэрлэх**

132³.1. Шүүгч мөнгөн зээлийн үйл ажиллагаа эрхлэх этгээдээс олгох зээлийн гэрээтэй холбогдолтой хэргийг хянан шийдвэрлэхдээ зохигчид эвлэрүүлэн зуучлалын журмаар эвлэрэх хугацаа зааж, нэхэмжлэлийг эвлэрүүлэн зуучлагчид шилжүүлэх арга хэмжээг урьдчилан авахаар захирамж гаргаж болно.

132³.2. Зохигчид эвлэрвэл шүүгч эвлэрлийг баталсан захирамж гаргаж шүүгч эвлэрлийн гэрээг баталгаажуулсан захирамж гаргаж хэргийг хэрэгсэхгүй болгох бөгөөд талууд, зохигч, тэдгээрийн төлөөлөгч, өмгөөлөгч давж заалдах, хяналтын журмаар гомдол гаргах, тухайн асуудлаар анхан шатны шүүхэд дахин нэхэмжлэл гаргах эрхгүй.

132³.3. Энэ хуулийн 132³.1-д заасан эвлэрүүлэн зуучлах ажиллагаа амжилтад хүрээгүй бол эвлэрүүлэн зуучлагч нэхэмжлэлийг шүүхэд шилжүүлнэ.”

2 дугаар зүйл. Энэ хуулийг Мөнгөн зээлийн үйл ажиллагааг зохицуулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

Төсөл

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2020 2022 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

МӨНГӨ УГААХ БОЛОН ТЕРРОРИЗМЫГ САНХҮҮЖҮҮЛЭХТЭЙ ТЭМЦЭХ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн 4 дүгээр зүйлд доор дурдсан агуулгатай 4.1.10-дэж **4.1.11 дэх** заалт нэмсүгэй:

“4.1.10. **4.1.11.** Мөнгөн зээлийн үйл ажиллагааг зохицуулах тухай хуульд заасан мөнгөн зээлийн үйл ажиллагаа эрхлэх этгээд.”

2 дугаар зүйл. Энэ хуулийг Мөнгөн зээлийн үйл ажиллагааг зохицуулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2020 2022 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

ЗӨРЧЛИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Зөрчлийн тухай хуульд доор дурдсан агуулгатай ~~41.33~~ дугаар **11.34 дүгээр** зүйл нэмсүгэй:

~~“41.33.~~ **11.34. Мөнгөн зээлийн үйл ажиллагааг зохицуулах тухай хууль зөрчих**

1. Мөнгөн зээлийн үйл ажиллагаа эрхлэх этгээд нь:

1.1. мөнгөн зээлийн үйл ажиллагаа эрхлэх этгээдийн тайлан тэнцэлд тусгаагүй мөнгөн хөрөнгийн эх үүсвэрийг өөрийн үйл ажиллагаанд ашигласан;

~~1.2. нэг удаа олгох зээлийн дээд хэмжээнээс хэтэрсэн зээл олгосон;~~

~~1.3. 1.2. зээлийн хүүгийн дээд хэмжээнээс хэтэрсэн хүү тогтоосон;~~

~~1.4. 1.3. нэмэгдүүлсэн хүүг хэтрүүлэн тогтоосон;~~

~~1.5. 1.4. анз хэрэглэсэн;~~

~~1.6. 1.5. мөнгөн зээл, түүний хүүг мөнгөн зээлийн үйл ажиллагаанд зориулсан банкны харилцах дансанд байршуулаагүй мөнгөн зээлийн үйл ажиллагаанд зориулсан банкны харилцах данснаас өөр дансанд мөнгөн зээл, түүний хүүг байршуулсан;~~

1.7. **1.6.** мөнгөн зээлийн үйл ажиллагааны зар сурталчилгааг дутуу, эсхүл буруу ташаа мэдээлэл агуулсан байдлаар хийсэн;

1.8. **1.7.** бүртгэлийн гэрчилгээгээ бусдад шилжүүлсэн;

1.9. **1.8.** зээлийн гэрээ байгуулсны шимтгэл, ~~эсхүл жураамж~~ **хураамж, эсхүл нэмэлт төлбөр** авсан;

1.10. **1.9.** зээлийн хүүг урьдчилан авсан бол учруулсан хохирол, нөхөн төлбөрийг гаргуулж хүнийг таван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг таван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

2. Барьцаалан зээлдүүлэх журмаар олгох мөнгөн зээлийн үйл ажиллагаа эрхлэх этгээд нь:

2.1. мөнгөн зээлийн үйл ажиллагаанаас өөр үйл ажиллагаа эрхэлсэн;

2.2. **ажлын байрны** байршлыг бүртгэх байгууллагад бүртгүүлэлгүйгээр өөрчилсөн;

~~2.3. даатгалд даатгуулаагүй;~~

2.4. **2.3.** барьцааны эрх хэрэгжүүлэх мэдэгдлийг хүргээгүй, эсхүл барьцааны шаардлагыг хангах эцсийн боломжит хугацааг хангаагүй;

~~2.5. 2.4. барьцааны зүйлийг худалдан борлуулсан орлогоос үлдсэн хэсгийг барьцаалуулагчид олгоогүй;~~

2.6. 2.5 үйл ажиллагаагаа зогсоох төхиөлдөлд талаар гаргасан шийдвэрээ зээлийн гэрээ байгуулсан үйлчлүүлэгч бүрд мэдэгдээгүй, төлбөр тооцоог дуусгах арга хэмжээ аваагүй бол учруулсан хохирол, нөхөн төлбөрийг гаргуулж хуулийн этгээдийг таван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

~~3. Мөнгөн зээлийн зуучлалын үйл ажиллагаа эрхлэх этгээд нь:~~

~~3.1. үйлчилгээний шимтгэлийн дээд хэмжээг хэтрүүлэн тогтоосон, эсхүл бүртгэлгүй этгээдэд зуучлалын үйлчилгээ үзүүлсэн бол учруулсан хохирол, нөхөн төлбөрийг гаргуулж хуулийн этгээдийг таван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.~~

4. 3. Иргэн, хуулийн этгээд нь бүртгэлд бүртгүүлэхгүйгээр мөнгөн зээлийн үйл ажиллагаа, ~~эсхүл мөнгөн зээлийн зуучлалын үйл ажиллагаа~~ эрхэлсэн, эсхүл бүртгэлд бүртгүүлэхгүйгээр нэрэндээ “зээлийн үйлчилгээ”, “барьцаалан зээлдүүлэх газар”, ~~“зээлийн зуучлалын үйлчилгээ”~~ гэсэн тэмдэглэгээ, эсхүл тэдгээртэй түүнтэй төсөөтэй тэмдэглэгээ хэрэглэсэн бол учруулсан хохирол, нөхөн төлбөрийг гаргуулж хүнийг таван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг таван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

5. 4. Иргэн, хуулийн этгээд нь бүртгэлд бүртгүүлэхгүйгээр мөнгөн зээлийн үйл ажиллагааны, ~~эсхүл мөнгөн зээлийн зуучлалын үйл ажиллагааны~~ талаар зар сурталчилгаа хийсэн бол учруулсан хохирол, нөхөн төлбөрийг гаргуулж хүнийг хоёр зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг хоёр мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.”

2 дугаар зүйл. Энэ хуулийг Мөнгөн зээлийн үйл ажиллагааг зохицуулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

Төсөл

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2020 ~~2022~~ оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

ЗӨРЧИЛ ШАЛГАН ШИЙДВЭРЛЭХ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 1.8 дугаар зүйлийн 6.18 дахь заалтын “11.30 **11.33**,” гэсний дараа “11.33-**11.34**,” гэж нэмсүгэй.

2 дугаар зүйл. Энэ хуулийг Мөнгөн зээлийн үйл ажиллагааг зохицуулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2020 2022 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

УЛСЫН ТЭМДЭГГИЙН ХУРААМЖИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуульд 18¹ дүгээр зүйл нэмсүгэй:

**“18¹ дүгээр зүйл. Мөнгөн зээлийн үйл ажиллагаа
~~болон мөнгөн зээлийн зуучлалын үйл ажиллагаа~~
эрхлэхэд бүртгэлийн гэрчилгээ олгох
тэмдэгтийн хураамжийн хэмжээ**

18¹.1. Барьцаалан зээлдүүлэх журмаар болон иргэнээс байнга, ашиг олох зорилгоор олгох мөнгөн зээлийн үйл ажиллагаа, ~~мөнгөн зээлийн зуучлалын үйл ажиллагаа~~ эрхлэхийг хүссэн этгээдэд ~~бүртгэлийн гэрчилгээ өлгөж, бүртгэлийн гэрчилгээг сунгахад~~ **олгоход** доор дурдсан хэмжээгээр тэмдэгтийн хураамж хураана:

18¹.1.1. Барьцаалан зээлдүүлэх журмаар олгох мөнгөн зээлийн үйл ажиллагаа, иргэнээс байнга, ашиг олох зорилгоор олгох мөнгөн зээлийн үйл ажиллагаа, ~~мөнгөн зээлийн зуучлалын үйл ажиллагаа~~ эрхлэхийг хүссэн этгээдэд мөнгөн зээлийн ~~болон зуучлалын үйл ажиллагаа~~ эрхлэх этгээдийн ~~бүртгэлийн гэрчилгээ олгоход~~ 100,000-250,000 төгрөг;”

~~“18¹.1.2. Энэ хуулийн 18¹.1.1-д заасан мөнгөн зээлийн болон зуучлалын үйл ажиллагаа эрхлэх этгээдийн бүртгэлийн гэрчилгээг сунгахад 50,000-125,000 төгрөг.”~~

2 дугаар зүйл. Энэ хуулийг Мөнгөн зээлийн үйл ажиллагааг зохицуулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

~~2020~~ 2022 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

ҮЛ ХӨДЛӨХ ЭД ХӨРӨНГИЙН БАРЬЦААНЫ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Үл хөдлөх эд хөрөнгийн барьцааны тухай хуулийн 6 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 6.2 дахь хэсэг нэмсүгэй:

“6.2.Мөнгөн зээлийн үйл ажиллагааг зохицуулах тухай хуулийн ~~26-4~~
12.1-д заасан этгээдээс олгосон зээлийн гэрээг бүртгэхгүй.”

2 дугаар зүйл. Энэ хуулийг Мөнгөн зээлийн үйл ажиллагааг зохицуулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2020 2022 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ЭРХ ЗҮЙН БАЙДЛЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай дараах заалт нэмсүгэй:

~~1/6 дугаар зүйлийн 6.1.12 дахь заалт:~~

~~“6.1.12-иргэдэд санхүүгийн боловсрол олгох ажлыг зохион байгуулах.”~~

2 1/6 дугаар зүйлийн 6.2.8 дахь 6.2.9 дэх заалт:

“~~6.2.8.~~ **6.2.9.** Мөнгөн зээлийн үйл ажиллагааг зохицуулах тухай хуульд заасан.”

2 дугаар зүйл. Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.5 дахь хэсгийн “зүйлд” гэснийг “зүйл, Мөнгөн зээлийн үйл ажиллагааг зохицуулах тухай хуульд” гэж өөрчилсүгэй.

3 дугаар зүйл. Энэ хуулийг Мөнгөн зээлийн үйл ажиллагааг зохицуулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

